



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 8/125

Арвайхээр


Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт  
урамшуулал олгох тухай

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7<sup>1</sup> дүгээр зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын үед эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж буй өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ажлын ачаалал нэмэгдэж, ажлын тусгай горимоор ажиллаж байгааг харгалзан өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгосугай.

2. Мөнгөн урамшууллыг тухайн байгууллагын төсвөөс гаргахыг өрхийн эрүүл мэндийн төвүүд хариуцсан Нягтлан бодогч (А.Туяамаа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ГАНБАТ

371100240

D:2021/Alban bichig/Zahiramj2021